

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-25
1. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	6-23
2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	23-25

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 24-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 12 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Батлут, Г.Ганбаатар, Х.Ганхуяг, П.Мөнхтулга, З.Мэндсайхан;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Нэг.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, референт Б.Төрбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Н.Алтанхуяг, Х.Булгантуяа, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

2.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /“Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн, нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: ““Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 16 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим, 10 цаг 12 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Байнгын хорооны хуралд ирэх ёстой 25 гишүүнээс 13 гишүүн ирээд, ирц 52 хувьтай байна. Ирц бүрдсэн тул 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Төсвийн байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдааны ирцийг та бүхэнд танилцуулъя. Т.Аубакир, Б.Батцэцэг, Ж.Ганбаатар, Б.Мөнхсоёл, Б.Түвшин, Р.Батболд, Х.Болормаа, Ц.Даваасүрэн, Д.Пүрэвдаваа, Да.Цогтбаатар, Ж.Батжаргал, Х.Булгантуяа, Г.Дамдинням, Г.Тэмүүлэн нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа. Эхний асуудал Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг байгаа.

2 дахь асуудал Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүн байна уу. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд байж байгаа Гаалийн албан татварыг чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болгох тухай хууль хэлэлцэж байгаатай холбогдуулаад энэ хууль батлагдахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоол гаргах шаардлага байгаад байгаа юм. Газар тариалан, гурилын үйлдвэрлэлийн тогтвортой байдал, хангалт нийлүүлэлт, үнэ ханшийн тогтвортой байдлыг хангах хүрээнд Засгийн газарт тодорхой чиглэл гаргаж өгөх шаардлага байна гэж манай олон гишүүд хэлэлцүүлгийн явцад үзээд байгаа.

Тийм учраас өнөөдрийн Байнгын хорооноос ажлын хэсэг байгуулаад, тэрхүү тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хороондоо оруулж ирэх ийм ажлын хэсэг байгуулж өгөөч ээ. Ийм асуудлыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж өгөөч ээ гэж хүсэж байна.

Ц.Даваасүрэн: Энэ угаасаа өмнө нөгөө уначихсан Гаалийн албан татвараас чөлөөлөх хуультай хамт бас явж байсан тогтоол шүү дээ. Тийм учраас энэ тогтоолын төслийг заавал Улсын Их Хурлын гишүүн санаачлах ёстой. Хэдийгээр Байнгын хороо гэж байгаа боловч Улсын Их Хурлын гишүүн санаачлах ёстой. Тийм учраас 2 дахь асуудлыг хэлэлцэхэд нэмэлт болгоод ажлын хэсэг байгуулаад тогтоолын төсөл санаачлах асуудлыг тусгаад явчихъя. Ингээд хэлэлцэх асуудлын талаар өөр санал байхгүй учраас хэлэлцэх асуудалдаа оръё.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Г.Занданшатар, С.Бямбацогт 2 сайдыг дуудаарай. Б.Жавхлан. Аль сайд нь ирэх юм. Д.Мөнх-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Д.Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Б.Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын референт, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн Засгийн газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга гэсэн хүмүүс оролцож байгаа юм байна. Сайд нар нь хаана байна. Сайд нараа дуудъя. Саяын сайд нараасаа аль нэгийг нь оруулъя.

Эхнээсээ ингэж мордохын хазгай болж болохгүй шүү. Хуулийн төсөл өргөн мэдүүлчхээд, тэгээд өөрсдөө ирж оролцохгүй байж болохгүй. Наадах чинь ер нь жоохон мордохын хазгай л болох гэж байна гэсэн үг шүү. Ер нь Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт орж байж сайд нар томилогдох ёстой байхгүй юу. Тэрнээс биш сайд нараа баталчхаад Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт ордог юм бол байж болохгүй шүү дээ. Тийм учраас энэ хууль чинь өөрөө хуулийн зөрчилтэй асуудал болчихоод байна шүү дээ. Сайд нар ирсэн учраас Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцээд явъя. Тэгээд зүйл бүртэй холбогдуулаад та бүгд асуултаа асуух юм байна шүү.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэх заалттай.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 4 зүйлтэй. Зүйл бүрээр хэлэлцье.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна. Батжаргал байгаа юм уу. Батжаргал гишүүн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуултаа асууя.

Ж.Батжаргал: Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анзаарч байна. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор дунд хугацааны төсвийн хүрээнийхээ мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон төсвийн тодотголын төслийг боловсруулахад энэ зүйлд заасан хэлэлцүүлэг хамаарахгүй гэж ийм үг байгаад байгаа юм. Хэлэлцүүлэг юмнуудыг бол тэгээд юу яаж болмоор гэж. Тэгэхдээ бид хэдийн яриад байгаа асуудал яг бүтэц бүрэлдэхүүнтэйгээ холбоотой юу гэдэг асуудал байгаад байгаа юм. Тодотголын асуудал маань үүн дээр нэг тодорхой мэдээлэл авчихмаар байна.

Ц.Даваасүрэн: Хэн хариулах юм. Жавхлан сайд 4 номерын микрофон өгье.

Б.Жавхлан: Түр байж байгаарай. Би асуултыг буруу ойлгочхоогүй байгаа. Батжаргал гишүүний асуултад хариулъя. Төсвийн тухай хуулийн 34.1 дүгээр заалт байгаа. 4 зүйлтэй. Тодотгол үүсгэх хуулийн шаардлагууд байгаа.

34.1.3 нь бол ДНБ-ий 3 хувь хүртэл алдагдал тооцооллоос хэтэрсэн тохиолдолд гэж байгаа

34.1.4 нь болохоор төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд зохицуулалт хийх шаардлага үүссэн бол гэж байгаа. Өөрөөр хэлбэл бид нарын яриад байгаагаар бол Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орох ийм тохиолдлыгоо хэлээд байгаа юм. Тийм учраас ДНБ-ий 3 хувьтай тэнцэх алдагдал хүрсэн гэдгийг эсвэл хүрнэ ч гэдэг юм уу ийм төсөөллөөр бид тодотгол хийвэл хууль зөрчинө. Дөнгөж гараагаа эхэлж байгаа Засгийн газрыгаа нэг тийм отоонд аваачаад хийчихмээргүй байгаа юм. Тийм учраас ямар ч хуулийн зөрчилгүй тодотгол хийх яг цорын ганц үндэслэл нь 34.1.4 буюу төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд төсвийн зохицуулалт хийх ийм шаардлага. Тэгэхээр өмнө нь явж байсан практикуудыг харахад яамдын болон бүтэц дотор цэг, таслал өөрчлөгдөхөд төсвийн эрхлэн захирагч нарын хооронд гүйлгээ хийх боломжгүй болж ирж байсан ийм тохиолдлууд байгаа. Тийм учраас яг тодотгол хийх үндэслэл, шаардлага нь болж байгаа юм. Энэ удаа бол бас багагүй өөрчлөлт орж байна. 3 яамгүй гэх юм уу сайд нарын хувьд бүтцэд нь өөрчлөлт ороод яамнууд руугаа шингэж байгаа. Мөн Үндэсний хороонууд татан буугдаж байгаа. Ийм үндэслэлээр тодотгол дараа нь хийгдэнэ.бол эхлээд дарааллын хувьд бүтэц бүрэлдэхүүндээ өөрчлөлт ороод, үүнийгээ үндэслээд төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд зохицуулалт хийх шаардлага үүссэн учраас төсвийн тодотгол өргөн барина гэсэн ийм логик дарааллаар явж байгаа.

Ц.Даваасүрэн: Хариулт болсон уу. Тодруулах уу. Батжаргал гишүүний микрофон.

Ж.Батжаргал: Хүрээний мэдэгдэл ер нь хэрэг байгаа юм уу бид хэдэд. Төсвийн хүрээний мэдэгдэлдээ өөрчлөлт оруулах асуудал ер нь хэрэг байгаа юм уу.

Ц.Даваасүрэн: 4 номер.

Б.Жавхлан: Дагасан 2 хууль дээр ийм зүйлүүд байгаа юм. Төсвийн тухай хууль дээр нь 14 хоног гэж байгаа. 14 хоног үнэхээр бас амжихгүй болох ийм тохиолдлууд гарах юм байна. Цаашдаа ч гэсэн. Төсвийн тогтвортой байдлын хууль дээр болохоор төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт орсноос хойш 3 сар төсөв болон төсвийн хүрээг тодотгол өргөн барих боломжгүй гэсэн ийм хуулийн хязгаарлалтуудтай юм. Яах вэ, эдгээр өөрчлөлтүүдийг орж байх үеийн нөхцөл байдал, үзэл баримтлалыг бол бүгдээрээ сайн ойлгож байгаа. Ер нь бол эдийн засгийн өсөлттэй, эдийн засгийн тэлэлттэй ийм үеүд. Дээрээс нь 6 сард багтаж, 5 сарын 31-нд төсвийн хүрээгээ баталчхаад, 9 сарын 1 гэдэг чинь 3 сарын дараа ирэх оны төсөв өргөн барих үед мөн өөрчлөлт ороод, төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх гэх юм бол 6 сар .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Энэ нөгөө төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсанаас хойш 3 сарын дотор төсвийг тодотгож болохгүй гэсэн заалт байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас хэрвээ нөгөө төсөв тодотгох 1 нөхцөл чинь Засгийн газрын бүтэц

бүрэлдэхүүнд өөрчлөлт ороод, салбар хооронд зохицуулах шаардлага гарвал гэж байгаа шүү дээ. Тэгээд тэр асуудал нь л болохгүй болчихоод байгаа учраас энэ өөрчлөлтийг хийгээд байгаа юм байна лээ шүү дээ. 1 дүгээр асуудлаар асуулт асууж дууслаа.

1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. 1 дүгээр зүйлийг хэлэлцлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байна. Кнопоо даръя. Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Ганбаатар: Сангийн сайдын хариултыг сонсохоор зөвхөн Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байгаа учраас л төсөв тодотгож байгаа юм уу. Үгүй ээ, тэгээд өөр шаардлага гэж гараагүй юм уу. Үгүй ээ Ерөнхий сайд төсвийн алдагдал нэлээн том тоо хэлнэ лээ шүү дээ. Тэгээд төсвийн алдагдал чинь өөрөө хамаагүй байгаа юм уу. Болоогүй байна л даа.

Дээрээс нь энэ валютын ханш ерөөсөө замаа алдлаа шүү дээ. Төсвийн алдагдал үнэхээр би гэж хэлэхэд хэцүү юм л даа. Бид хэчнээн удаа ярилаа. Хэдэн жил ярилаа. Мундаг байгаа, мундаг байгаа. Төчнөөн тонн нүүрс гаргана л гээд байсан. Тэгээд л чадна, болно л гээд байсан. Төсөв алдагдалгүй л гээд байсан. Тэгээд Ерөнхий сайд өчигдөр билүү, уржигдар билүү хэлж байна лээ шүү дээ. Тэгээд зөвхөн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний төлөө л төсвийн тодотголоор орох гэж байгаа гэдэг ийм хариулт бол хэтэрхий биеэ тоосон байдалтай байна даа.

Би бол энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн дээр бол яамнуудын тоог цөөрүүлж байгаа, төрийн албыг цомхон болгох гэж байгаа зөв. Маш сайн дэмжиж байгаа. Тэгээд ийм байдалтай энэ бол болохгүй л дээ. Төсвийн алдагдал чинь ингээд бүр замаа алдлаа шүү дээ. Экспорт чинь ямар болж байгаа билээ. Бодит байдалтайгаа эвлэрэхгүй юм уу. Бямбацогт сайд энийг бол сайн мэдэж байгаа шүү дээ. Тэгээд бодит байдалтайгаа эвлэрээд, энийгээ яахгүй бол намар энийгээ бүр гүйцэхээ болих нь. Тэр бүр тэндээ тулж байж төсвийн тодотгол, экспортынхоо асуудлыг ярих ийм байдалд хүрэх нь л дээ. Олон гишүүд хэлээд л байх шиг байна лээ л дээ. Сонсохгүй байх шиг байна. Тэгээд гадаа чинь юу болоод байгаа вэ. Иргэдийн чинь худалдан авах чадвар ямар байна. Аж ахуйн нэгжүүд чинь ноднин уржнантайгаа харьцуулахад ямар байна. Юмыг хийж дуусгаж үзээгүй хүмүүс мэддэггүй юм л даа. Зүгээр сонсчихсон хүн, ер нь бол юмыг сонсчихоод туулаагүй хүн бол мэдэхгүй шүү дээ. Тэгээд л ном зохиолоос уншсан юм уу, багшаар заалгачаад тэр бол бодит байдлаас шал өөр асуудал л даа. Улс орны байдал бол үнэхээр хүнд байна шүү дээ.

Зөвхөн тэгээд л Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноос л төсөв тодотгож байгаа гээд. Үнэхээр хангалтгүй байна даа. Уг Би бол Засгийн газрыг бүх талаараа дэмжиж ажиллана. Бүх талаас нь дэмжиж ажиллахыг .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Санал хэлсэн үү. Асуулт уу. Санал уу. Аль нь юм.

2 дугаар хэсэгтэй холбогдуулаад би нэг зүйл асууя. Энэ чинь нөгөө боомтын, 20 минутын, хяналт үнэлгээний гээд сайд нарын юуг төсвийн тухай хуулиас багцыг нь хасаж байгаа шүү дээ. Тэгээд би энэ дээр 1 зүйлийг бас протоколд үлдээсэй гэж бодоод байгаа юм. Энэ бүтэц, бүрэлдэхүүний асуудалд өөрчлөлт орно гэдэг чинь эхэлж хийгдэх ёстой байхгүй юу. Жишээлбэл эдийн засаг эрхэлсэн Шадар сайдын асуудлын хүрээнд хяналт үнэлгээг аваачаад нэмчхэж байна шүү дээ. Тэгээд энэ чинь шинэ сайд гарч ирж байгаа байхгүй юу. Гэтэл бид нар нөгөө сайдаа баталчихсан байгаад байгаа шүү дээ. Тэгээд энэ Эдийн засаг, хөгжлийн сайд гээд дахиж орж ирэх үү. Яагаад гэвэл бид нар энэ хяналт шинжилгээ, үнэлгээний хариуцаж байсан энэ сайдыг ингээд хаслаа Төсвийн тухай хуулиас. Тэгэнгүүт энэ хүний эрхэлж байсан асуудлуудыг чинь аваачаад эдийн засаг эрхэлсэн Шадар сайд руу нэмчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хүн чинь шинэ хүн болчихоод байна шүү дээ. Өмнөх албан тушаалтан биш байгаа байхгүй юу. Яагаад гэвэл функц нь өөрчлөгдчихсөн. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль дээр өөрчлөлт орчихсон. Тэгэхээр энэ сайд ахиж орж ирэхээс өөр арга байхгүй. Хэрвээ ингээд гүрийгээд явах юм бол тэр сайдын асуудал хэрвээ Цэц рүү очих юм бол гаргасан шийдвэр нь хүчингүй. Яагаад гэвэл энэ хуулиар энэ Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулиар энэ өөрчлөлт чинь орчхож байгаа байхгүй юу. Тэр сайд дээр. Шинэ сайд болчхож байгаа байхгүй юу. Гэтэл тэр сайдыг бид нар чинь оруулаад баталчихаад яваад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ асуудлыг яаж зохицуулах гэж байна вэ. Бямбацогт сайд хариулах юм уу. Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль Улсын Их Хурлаар батлуулах бол Монгол Улсын Ерөнхий сайдын өөрийнх нь онцгой бүрэн эрх Үндсэн хуульд заасан. Яг түүнтэй адилхан бас Засгийн газрын гишүүнийг томилж, эрхэлсэн сайдыг томилох асуудал бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бас Ерөнхий сайдын өөрийнх нь бүрэн эрхийн асуудал болсон. Энэ хүрээндээ өмнөх Засгийн газрын хийж хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг залгамжилж явъя гэдэг үүднээс хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр Улсын Их Хурлаар баталсан. 2024-2028 оны энд бас улс төрийн 5 нам бас хамтарсан парламент суудалтай энэ намуудын сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр, бодлого, зорилт туссан. Үүнийг бас хэрэгжүүлэх төрийн залгамж чанар байх ёстой гэдэг үүднээс өнөөдөр анх 2024 онд байгуулагдсан Засгийн газрын үндсэн яамтай сайд нарыг хэвээр нь үлдээе. Чиг үүргийнх нь дагуу ажиллуулъя. Тэр үндэсний хороод буюу яамгүй сайд нарын асуудлыг эргэж ярья гэж сайд нараа томилсон. Ингээд бас бүтэц, бүрэлдэхүүний асуудлыг оруулж ирэх асуудал яригдаж байх үед яамгүй сайд нарын хариуцаж байгаа чиг үүргүүдийг яамтай сайд нарт хариуцуулаад явж болох юм байна. Энэ хуучин ч бас ийм жишиг ийм байсан. Түүнээс нь салгаад аваад явсан юм байна. Тийм болохоор үүнд нь нэгтгээд буцаагаад явъя. Өөрөөр хэлэх юм бол боомтын Үндэсний хороо бол Боомтын үндэсний хорооны асуудлыг хуучин Сангийн яам хариуцаж байсан учраас Боомтын үндэсний хорооны асуудлыг чиг үүргийг Сангийн яаманд. Тэр Төлөвлөлтийн яам Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөдөг яам эргээд хяналтаа хийдэг байсан. Түүнтэй хуульд заагдсан тэр чиг үүргийнх нь дагуу Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрыг тэр Эдийн засаг, хөгжлийн яаманд ийм байдлаар үндсэндээ бол чиг үүргүүдийг нь хуваарилж, хуучин салгаад аваад явсныг буцаагаад нэгтгэх байдлаар л Бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа юм. Ингээд өнөөдөр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний асуудлыг Боомтын үндэсний хороо, нөгөөдөх нь Хяналт хэрэгжүүлэх ерөнхий газар, тэгээд 20 минутын хот. 20 минутын хотын асуудал ч гэсэн бас Барилга, хот байгуулалтын яаманд үндсэндээ байсан хот байгуулалтын асуудлыг хуучин

Барилга, хот байгуулалтын яам хариуцдаг байсан. Түүнээс нь тодорхой чиг үүргийг салгаад, 20 минутын хот Үндэсний хороо байгуулсан байсан. Тэр лүү л нийлүүлсэн. Ийм байдлаар явж байгаа болохоор энд ямар нэгэн тийм хуулийн зөрчил гарахгүй гэдгийг хэлье.

Тэгээд бүрэлдэхүүний хууль өөрчлөгдөж байгаа холбоотой төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөвт зарцуулах хуультай холбоотой Төсвийн тухай хуульд зав суусан томъёоллууд нь өөрчлөгдөж байгаа учраас үүнтэй холбоотойгоор Төсвийн тухай хуульд өөрчлөлт хийх асуудал орж ирж байгаа гэдгийг бас хэлье.

Ц.Даваасүрэн: Миний асуугаад байгаа нөгөө Боомтын сайд, энэ 20 минутын сайд, Хяналтын сайдыг чинь ажил үүргүүдийг нь өөр сайд руу хариуцуулаад явчихаар тэр сайд чинь кабинетын шинэ сайд гаргаж ирээд байгаа байхгүй юу. Шинэ сайд. Тийм учраас энэ шинэ сайдаа дахиж томилох уу л гэж би асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол энэ чинь болохгүй шүү дээ. Яагаад гэвэл энэ чинь Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт орчхож байгаа байхгүй юу. Тэр хүн чинь шинээр шинэ кабинет бүрдэж байна шүү дээ. Тэгээд угаасаа ийм жишиг хэзээ ч байгаагүй байхгүй юу. Эхэлж заавал бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байж шинэ кабинет бүрдэж байж, сайдаа томилдог байсан байхгүй юу. Одоо гэтэл энэ 3 сайдын ажил үүргийг чинь ахиад өөр сайд руу өгчихөөр шинэ сайд болчихоод байгаа байхгүй юу. Шинэ Засгийн газрын бүрэлдэхүүн болчихоод байгаа байхгүй юу. Үгүй ээ үгүй. Шинэ сайд гарч ирчхээд байгаа байхгүй юу энэ чинь. Яагаад гэвэл Засгийн газрын тухай хуульд нь өөрчлөлт орчхож байгаа байхгүй юу. 6. Албан тушаалаа хэлээд, тэгээд хариул.

Д.Мөнх-Эрдэнэ: Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая. Даваасүрэн даргын асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Мөнх-Эрдэнэ хариулъя.

Энэ Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт гэж байгаа. Энэ заалт дээр энэ хуулиар тогтоосон үндсэн хүрээнд Засгийн газрын гишүүдийн эрхлэх ажлыг тодруулан хуваарилж, түүний гүйцэтгэлд хяналт тавина. Шаардлагатай бол тэдгээрт нэмэлт ажил үүрэг хариуцуулж болно. Хэрэв энэ хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг буюу сайд нарын эрхлэх ажлын хүрээнд хүрээг нэгээс нөгөөд шилжүүлэх, нэг орон тоонд нэгтгэх, шинэ орон тоонд тусгаарлан хариуцуулах зэрэг өөрчлөлт оруулах бол энэ тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлсний үндсэн дээр гүйцэтгэнэ гэж Ерөнхий сайдын бүрэн эрх дээр заасан байдаг. Тэгээд яг энэ хуулийн заалтын дагуу энэ хуулийн төсөл орж ирсэн гэдгийг хэлье. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Тэгээд анхаарна биз. Яагаад гэвэл энэ чинь кабинетын чинь бүтэц, бүрэлдэхүүнийг одоо баталж байгаа болж таараад байгаа байхгүй юу. Тэгэхээр практик бас тийм. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнээ баталчихаад сайд нараа томилж ирсэн. Өнгөрсөн хугацаанд тэгсэн. Одоо ингээд араас нь өөрчлөөд байгаа байхгүй юу. Энэ чинь буруу жишиг орж ирж байна шүү дээ. Буруу. Наадах чинь хэрвээ Цэцэд очвол унана. Тэгэхдээ энийгээ бас та нар анхаарч засах талаас нь анхаараарай л гэж би хэлээд байна шүү дээ. Ингээд зүтгээд байвал та нар өөрсдийгөө хүнд байдалд оруулж магадгүй шүү. Яагаад гэвэл энэ сайд чинь кабинетаас шинэ ажил эрхэлсэн шинэ хүн гарч ирчхээд байна гэдгийг та нар ойлгох хэрэгтэй байгаад байгаа юм шүү.

2 дугаар асуудал дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу. Алга байна. Ингээд 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу. Алтанхуяг гишүүн. Кнопоо даръя. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Бямбацогт сайд, Мөнх-Эрдэнэ дарга аа, та нар уг нь бол Засгийн газрын бүтцийн тухай хууль эхлээд батлагдана гэж хэлээд байгаа нь үнэн шүү дээ. Тэр чинь нөгөө ямар сайдын эрхлэх асуудлын хүрээнд ямар, ямар асуудлууд байх вэ гэдгээ бичнэ шүү дээ. Тэгэхээр чинь зарим нэг сайд байхгүй болчихсон тохиолдолд тэрний эрхэлж байгаа асуудлын хүрээнд байгаа асуудлыг нөгөө тийшээ бичнэ. Тэгэхээр энэ чинь хуучин бид нарын ойлгож байгаа ойлголтоор Засгийн газрын бүтэц болчихоод байгаа байхгүй юу. Бүтэц, бүрэлдэхүүн. Эхлээд тэг тэгээд явбал та нарт дараа нь асуудал үүсэхгүй зөв юм биш үү. Та нар жаахан ярихгүй юм уу. Хамаа алга ингээд хураана гэвэл хураагаад л яв л даа. Би бол хурдан ажлаа хийгээд юм ярихгүй байгаа байхгүй юу. Тэгэхдээ сүүлдээ нэг ийм жонхуу, хуулийн зөрчил үүсгээд, тэгээд л эргэж тойроод ажил хийлгэхгүй байх вий дээ гэдэг санал хэлж байна шүү. Хүн чинь байхгүй болчихоор тэр функц чинь өөр хүн рүү шилждэг л байхгүй юу. Эхлээд тэр чинь батлагдчихлаар тэгээд л асуудалгүй л дээ. Үгүй ээ яах вэ, Даваасүрэн сайд бол шинэ сайд гээд байна. Би болохоор хуучин сайдын эрхлэх асуудлын хүрээнд шинэ асуудлууд орж ирсэн гэж бас томъёолж болно. Энэ өмнө нь тийм практик ч байсан. Жишээ нь гадаадын зээл тусламжийн асуудал Сангийн сайд дээр байх уу, Эдийн засгийн сайд дээр байх уу гэж маргаж байгаад тэгээд тэр сайдаасаа өмнө функцээ хийж байсан.

Ц.Даваасүрэн: Хөөш чи чуулганы Байнгын хорооны хуралд орж ирчхээд битгий ингээд агсам тавиад бай. Хөөш би чамд нэг юм хэлчихье. Улсын Их Хурлын гишүүн хуралдааны явцад үг хэлэхийг наадах чинь хуулиар хариуцлага хүлээдэггүй юм. Чи зүгээр л тэрийг нь бодоод хүндэтгээд дуугүй сууж бай. Энэ хүнээ гаргая. Энэ хүнээ гаргая, энэ хүнээ гарга.

Булгантуяа гишүүн асуултаа асууя. Алтанхуяг гишүүний асуултад хариулаагүй байгаа юм байна шүү дээ. Одоо ингээд хуралдааны дэг алдагдуулаад жоохон тайван байцгаа нөхөд өө. Жавхлан сайд. 4 номерын микрофон асуултад хариулъя.

Б.Жавхлан: Алтанхуяг гишүүний асуултад хариулах ч юу байх вэ дээ саналаа хэлэх гэсэн юм. Алтанхуяг гишүүнд баярлалаа. Ерөнхий сайд байсан хүн бас зовлон сайн ойлгож байгаа байх. Сая бол нөгөө хугацааны хувьд маш их тийм давчуу, бас дараа нь ингээд тодотгол залгах учраас ийм нэг хайчинд орж ирсэн шүү дээ. Тийм учраас одоо яг гарц нь хамгийн товч явах, хугацаа юмных гарц нь л энэ байгаа юм. Тэгээд яах вэ, манай энэ чинь Хэрэг эрхлэхийн бүхэл бүтэн хуулийн баг ажиллаж байгаа учраас бас хуулийн зөрчил үүсэхгүй л гэж үзсэн юм. Тэр нарийн ширийн нюансыг нь бас яг хуульчдын түвшинд сайн хэлж мэдэхгүй байгаад байна. Гэхдээ ямар ч байсан Ерөнхий сайдын хувьд байгаа бүтэц дээрээ сайд нараа томилоод, ажилдаа орохгүй бол бас л хугацаа алдах байсан. Дахиад бид нар нөгөө сайд нар чинь үүрэг гүйцэтгэгч нь, сайд үүрэг гүйцэтгэгч нар шинэ Ерөнхий сайд томилогдохоор үүрэг гүйцэтгэгч гэж байхгүй болчихож байгаа юм. Тэгэхээр энэ чинь кабинет нь байхгүй болчихоор энэ дараагийн ажил руугаа орж

болохгүй. Өнөөдрийн энэ юмнуудаа өргөн барьж чадахгүй ийм л юм руу бас явж орчих гээд байсан ийм зовлон байгаа. Тийм учраас байгаа бүтэц дээрээ сайд нараа томилж аваад, ажлаа үргэлжлүүлээд, ингээд одоо бүтцээ оруулж ирээд, тэгээд бүтцийнхээ дагуу тодотголоо оруулаад явах ийм л логиктой байгаа л зүйл юм.

Ц.Даваасүрэн: Алтанхуяг гишүүний анхаараад байгаа яагаад гэвэл Ерөнхий сайд орчихсон учраас тэр Засгийн газрын кабинет байхгүй болчхож байгаа байхгүй юу. Тэрнээс биш тэрийг үргэлжлүүлнэ гэдэг ойлголт байхгүй байхгүй юу. Тэгэхээр дахиад шинэ Засгийн газрын тэргүүн гарч ирэнгүүтээ кабинетаа бүрдүүлэх ёстой. Тэр бүрэн эрх нь байгаа. Тэгэхдээ энийгээ хэн хэнээ хариуцуулахаа баталж байж хийх ёстой байсан байхгүй юу. Бямбацогт гишүүн нэмж тайлбар өгөх юм уу.

С.Бямбацогт: Сая Засгийн газрын тухай хуульд Монгол Улсын Ерөнхий сайдын эдлэх онцгой бүрэн эрх. Үүний талаар сая маш тодорхой хуулийн зүйл заалтыг сая тайлбарласан. Үүний дагуу үндсэндээ Монгол Улсын Ерөнхий сайд бол Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг Их Хурлаар батлуулах, ямархуу бүтэцтэй ажиллах вэ, ямар бүрэлдэхүүнтэй байх вэ, Засгийн газрын гишүүнийг томилох асуудал бол өөрийнх нь онцгой бүрэн эрх. Энэ хүрээндээ гишүүдийнхээ асуудлыг хэлж оруулж ирсэн. Засгийн газрын гишүүнийхээ. Араас нь ингээд бүрэлдэхүүний асуудлыг оруулж ирж байгаа. Энэ жишиг бол хуучин байсан уу гэвэл байсан. Эдийн засаг, хөгжлийн сайдаар Хүрэлбаатар сайдыг томилчхоод, дараад нь Төсвийн тухай хууль дагуулаад Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулаад, Монгол Улсын Шадар сайд гэж бас томилж байсан. Иймэрхүү бүрэлдэхүүнтэй холбоотой төсөв дагуулаад Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудал, хуулиар хүлээсэн хариуцлага чиг үүргүүдийг хооронд нь .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Хүрэлбаатарын тэр ч гэсэн дээ бас л зөрчилтэй эд байхгүй юу. Төсвийн тухай хуулийг дагалдуулж оруулж ирж хүний ажил үүргийг өөрчилсөн тийм нэг луйвар явсан юм. Булгантуяа гишүүн асуултаа асууя.

Х.Булгантуяа: Би нэг ийм юу асуух гэсэн юм. 1 дүгээрт боомтын асуудлыг Сангийн сайдад хариуцуулж байгаа юм байна. Хуучин боомтын асуудал, Боомтын үндэсний хороо нь Сангийн сайд ахалдаг байсан. Одоо бол хэдүүлээ боомтын сэргэлт гээд нэлээдгүй юм хийчихлээ. Орост бол Зам, тээврийн сайд нь хариуцдаг. Яагаад гэвэл тэр чигээрээ тээвэр логистикийн асуудал байдаг. Зарим улс оронд Эдийн засаг, хөгжлийн сайд нь хариуцдаг. Бид нар бас Эдийн засаг, хөгжлийн яаман дээр гадаад худалдаагаа хариуцуулаад, гадаадын хөрөнгө оруулалтын тэр битгий хэл асуудлууд хариуцагдаж байгаа байсан цаг үед эсвэл тэндээ байх ёстой байх байсан юм биш үү. Сангийн сайдын доор бол төсвийн орлогыг бүрдүүлдэг татвар, гааль гээд 2 том бүтэц байдаг. Сангийн сайд бол үүнийгээ хариуцаад явах нь бол угаасаа зүйтэй. Тэгэнгүүт 1 ийм л юм үүсчхээд байдаг юм байна лээ л дээ. Хил дээр 2 том хүчтэй байгууллага байдаг. Гааль, Хил хамгаалах 2 гээд. Тэгээд Гааль гэдэг том айлдаа нөгөөдөх нь бас ингээд уусаад орчих гээд байдаг.

Тэгээд нөгөө боомтынх нь асуудал хариуцсан бүтэц, бүрэлдэхүүн нь, хил хамгаалах нь түүнийхээ доор орчих гээд ч байгаа юм шиг болчхоод байдаг ийм үзэгдэл байгаад байдаг учраас юун төлөө эдийн засгийн асуудал хариуцсан Тэргүүн Шадар сайдтай гэж болсон билээ. Энэ бол гадаад худалдааны боомт бол нэг том механизм учраас тэндээ байх ёстой байсан юм биш үү. Сангийн сайдын дэргэд бол өмнө нь гэхдээ ийм бүтэцгүй байхад бол нэлээдгүй сайн ажиллаж

байсан. Гааль гэдэг том бүтцээр ажиллаж байсан. Хятадад бол энэ бол та мэднэ шүү дээ. Гаалийн дарга нь Боомтынхоо даргыг хийгээд явж байгаа. Тэгэхдээ тэр нь Гаалийн дарга нь бол сайдын ранктай хүн. Өвөр Монголынх гэхэд Өвөр Монголынх нь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэд дарга бөгөөд Боомтын дарга гэж явж байгаа. Худалдаатайгаа уяж явдаг энэ бүтэц. Гэтэл манайд бол ийм төсвийн орлого бүрдүүлдэг гаальтайгаа очоод уягдчих юм биш шүү дээ. Тэр дээрээ та бүхэн маань буцаад өмнөх засах гэж байсан юм руугаа буцаад орчих вий дээ 1 дүгээрт.

2 дугаарт өргөн барьсан хууль дээр 3 сарын дотор өөрчлөлт оруулж болохгүй гэдгийг л өөрчлөх гэж л оруулж ирсэн юм шиг байна. Одоо тэгэхээр зөвхөн бүтэцтэй холбоотой өөрчлөлтийг хийх гэж байгаа юм шиг уншигдаад. Гэтэл та бүхэн төсвийнхөө тодотголоо өргөн барихдаа орлого бас тасарч байгаатай холбоотойгоор өргөн барьж байгаа гээд. Тэгэхдээ ер нь ингэж харагдаж байна лээ Төсвийн байнгын хорооны дарга аа, энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-ыг уг нь бол санаа нь болохоор бол хавар нь бид нар төсвийн хүрээгээ батлуулангуутаа намар төсвөө өргөн барихдаа төсвийнхөө хүрээг өөрчилчхөөд байгааг л больё гэж л үүнийг анх оруулж ирсэн. Гэтэл төсвийн тодотгол хийхэд энэ чинь орлого тасарвал бид нар төсвийнхөө хүрээний тодотгол хийх хүрээгээ өөрчилчхөөд ахиад 3 сар хүлээж байж тодотголоо өргөн барина гэхээр тэр хоорондуур чинь төсөв бүүр хүндэрчихнэ биз дээ. Яг одоогийн нөхцөл байдлыг харах юм бол. Тэгэхээр үүнийг 7.5-ыг жоохон өөрчлөхгүй бол төсөв хүндрэх юм бол төсвийн тодотгол хийхийн аргагүй дор хаяж 3 сар хүлээхээс өөр аргагүй ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа. Эсвэл одоогийнх шиг Засгийн газрынхаа бүтэц .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Тийм байна. Яах вэ ер нь төсвийн тодотгол хийх 3, 4 нөхцөл чинь биелчих юм бол энэ заалт хамаарахгүй гэж л өөрчлөх хэрэгтэй юм шиг байна лээ л дээ. Тэгэхгүй болохоор Засгийн газрын бүрэлдэхүүнийг гэж өөрчлөөд байгаа чинь бас учир дутагдалтай гэж хэлээд байна. Жавхлан сайд, дараа нь Бямбацогт сайд. 4 номерын микрофон өгье.

Б.Жавхлан: Харин тийм. Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Дарааллаар нь хариулъя. 3 зүйл ярилаа. Боомтын асуудал дээр Засгийн газар дээр ингэж яригдсан юм. Ер нь бол энэ Сангийн яамны эрхлэх асуудал дээр байсан. Сайдтай болтол. Би өөрөө санал гаргаж байсан. Энэ боомтын асуудал бол манай гадаад худалдааны эдийн засагтай улсын хувьд бол их чухал. Тийм учраас тусдаа өөрөө бие даасан сайдтай байвал илүү их үр дүн гарах юм байна. Тэгээд ч шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд боомтын асуудал өөрөө их чухал асуудал байсан учраас ингэж фокус өгч байсан. Одоо ингээд буцаад бас орлого төлөвлөгөөтэй холбоотой Засгийн газар яалт ч байхгүй зардлаа хэмнэх, хумих ийм нөхцөл байдал үүсэж байгаа учраас яамгүй 3 сайд дээрээ ийм арга хэмжээ авч байгаа. Аль яам руу нэгтгэх ү гэдгийг бас нэлээн ярьсан байгаа. Яах вэ дэд бүтцийн яамнууд руу бас тийм улсууд байдаг байх. Тэгэхдээ энэ удаа бол манай худалдааны эдийн засагтай улсын хувьд бол энэ илүү их эдийн засаг тал руугаа салбар хоорондын зохицуулалтын асуудал болж үүснэ. Дээрээс нь Булгантуяа сайд сайн мэдэж байгаа байх. Таныг дэд сайд байх үед ч бас хэлж байсан. Манай боомтуудаас одоо ер нь бараг 80 хувьд нь бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж, яг ид хийгдэж байгаа ийм үе нь. Азийн хөгжлийн банк, Хятадын буцалтгүй тусламжаар 2 том төсөл хэрэгжиж байгаа. Энэ төслүүд ч гэсэн уг нь манай дээр байсан юм. Тэгээд боомтын сайдтай болохоор дагуулаад явуулж байсан. Эдгээр

ажлууд бас ковидын үед нэлээн саатсан. Хөрөнгө мөнгө нь саатсан. Ер нь бол бараг 80, 90 хувийн ажлыг нь манайх хийж байгаа. Энэ төслүүдийнх нь хөрөнгө санхүүтэй холбоотой, энийг тасалдахгүй байх. Тийм учраас ерөөсөө ойрын жилүүдэд бүтээн байгуулалтын ажлуудыг яаралтай дуусгах салбар хоорондынх нь зохицуулалтуудыг хийх ийм ажлууд үе шат байна. Тийм ч учраас манай дээр ингэж шилжиж ирлээ гэж бид ойлгож байгаа.

Мөн энэ Мянганы сорилтын сангийн том төслүүд байна. Том төсөл байна. Энэ бас Гадаад харилцааны яам дээр нэлээн удсан. Тэнд мөн л бас төсөлтэй холбоотойгоор нэлээн ийм зогсонги байдалтай байсан. Сангийн яам руу шилжүүлж авсан. Сүүлийн жилүүдэд гүйцэтгэл өндөр явж байгаа ийм практикуудыг харсан байх. Ингээд Сангийн яам руу шилжиж байгаа гэдгийг хэлье.

Тэр 3 сар гэдэг дээр нэг ийм зүйл тэгээд хууль бол амьдрал дээр ингээд л шалгагдаад л болж байгаа нь болж байгаа, болохгүй нь болохгүй гээд л гараад ирдэг шүү дээ. Тэр 3 сар гэдэг заалтын өмнө тухайн жилийн гэдэг үг, үсэг байхгүй байгаа юм. Бид нар чинь 2 хүрээ яриад байна шүү дээ. Сая 6 сард 2026 оны хүрээ баталсан. Одоо бид нарын тодотгол хийх гэж байгаа чинь 2025 оны хүрээ. Шал өөр өөр хүрээ байхгүй юу. 6 сарын хүрээг баталчхаад, тэрнээс хойш 3 сар. Эсвэл одоо 2025 оны хүрээг одоо 7 сард өөрчилчхөөд 9 сар гэдэг 2 хугацаа чинь ингээд 2 өөр ойлголт болчхоод байгаа юм. Энэ өөрчлөлт дотор тэр өмнө нь тухайн жилийн гэдгийг нь оруулж байгаа шүү. Тэгээд иймэрхүү заалт зохицуулалтууд байгаа юм. Тэгэхээр хэдүүлээ хуулийн хайчинд ингээд хаанаас нь ч тайлбарлаад, мушгиад Засгийн газрыг оролдоод байж болохоор ийм заалтууд байгаад байгаа байхгүй юу. Тухайн жилийн гэдэг үг байхгүй учраас та нар 7 сард 2025 оныхыгоо өөрчилсөн. Биш ээ, 6 сард 2026 оныхыгоо цоо шинээр баталсан гээд л нэг хайчин дотор аль руу нь ч мушгиад, чирээд яваад байж болохоор иймэрхүү заалт байгаа учраас энийгээ нэг тийш нь болгочхож байгаа л гэж байгаа юм. Тэрнээс биш энд сахилга бат хөндөгдөх зүйл ерөөсөө огт байхгүй шүү гэдгийг хэлье.

Тэгээд тодотголоо өргөн бариагүй байна. Тодотголоо өргөн бариагүй байна. Одоо бүтэц, бүрэлдэхүүн ярьж байна. Бүтэц, бүрэлдэхүүн батлагдмагц тодотголоо яаж өргөн барих вэ, 34.1.2-оор уу, 34.1.4 ү. Эсвэл хоёуланг нь үндэслээд өргөн барьсан ч болно. Энд ерөөсөө ямар ч тийм саад байхгүй. Ер нь бол алдагдлыг болзошгүй ийм эрсдэл үүсэх нөхцөл байдал үүсэж байна гэдэг ирээдүй цаг дээр л ярьж орох болчхоод байгаа юм. Тэрийг бас л мушгина. Уг нь бол тодорхойлолтууд нь энэ чинь заалтууд нь дандаа өнгөрсөн цаг дээр байдаг байхгүй юу. Гүйцэтгэл нь тэд гарсан бол, тийм тохиолдол үүссэн бол гэсэн ийм заалтуудтай. Тэгтэл намар ханш ингээд унасан учраас намар тийм алдагдал .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Бямбацогт сайд хариулах юм уу. Болчихсон уу. Яах вэ зүгээр Булгантуяа гишүүний асуугаад байгаа бас үндэслэлтэй байж магадгүй. Хэрвээ хэлэлцүүлгийн явцад шаардлагатай гэвэл хэдүүлээ зарчмын зөрүүтэй санал гаргаад нэмж болно. Зөвхөн бүтэц, бүрэлдэхүүн гэснээр тодотгол хийж болохыг нээгээд яах вэ. Нөгөө тодотгол хийх 3, 4 нөхцөл чинь энэ 3 сарын хугацаанд гарч ирэх юм бол хийдэг байя гээд байгаа чинь зөв шүү дээ. Одоо жишээлбэл, нөгөө 3, 4 нөхцөлийг чинь нөгөө 2 нөхцөл нь өнөөдөр бүрдчихсэн байвал хийхээс өөр аргагүй шүү дээ. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл болохгүй гэж байна гээд суугаад байж болохгүй байхгүй юу. Тийм учраас зөвхөн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах гэхгүйгээр Тогтвортой байдлын тухай хуулийн тэд дүгээр заалтууд тодотгол хийх нөхцөл бүрдсэн тохиолдолд энэ хуулийн заалт

хамаарахгүй гэж өөрчилье гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр би зөв байж магадгүй гэж бодоод байгаа юм. 4 номер.

Б.Жавхлан: Бид нар уг нь бас яг эхний сайн хувилбар нь бол ингэж ярьж байсан юм. Тэгээд яг бас бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотойгоор суурь хууль дээр маш том заалт орж ирэх гээд, энэ чинь нүсэр заалт болох гээд байгаа байхгүй юу. 34.1-ийг уг нь бүхэлд нь оруулж ирээд ийм тохиолдлууд тэр 3 сарын хугацаанд үүссэн бол энэ 3 сар хамаарахгүй гэдэг ийм хувилбар дээр бид нар ярьж байсан юм. Одоо энийг тэгж өөрчилж болно шүү дээ. Хөндчихсөн учраас санал гаргаад зарчмын зөрүүтэй санал гаргаад ингээд өөрчилчихвөл бүр маш сайн болно. Ямар ч хуулийн зөрчилгүй явна.

Ц.Даваасүрэн: Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Сая 34.1.4-д нь болохоор нөгөө төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийг шилжүүлэх асуудал үүссэн бол Засгийн газар яаралтай төсвийн тодотгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасны дагуу одоо орж ирж байгаа юм. Тэгээд үүний дагуу явсны дараа бол нөгөө 14 хоног хэлэлцүүлэг байхгүй нэн яаралтай горимоор төсвийн тодотгол өргөн барих эрх үүсэхээр тэр төсвийн тодотголыг өргөн барих үедээ 34 дүгээр зүйлийн ийм, ийм заалтууд эдийн засагт төсвийн орлого тасалдах ийм онцгой нөхцөл байдал гээд ингээд өргөн бариад явах бололцоотой гэж харж байгаа юм.

Түрүүн чиг үүргийн тухайд нэлээн ярилцсан. Эдийн засаг, хөгжлийн яаманд боомтын чиг үүрэг байх уу, Сангийн яаманд байх уу. Зам, тээврийн яам дээр байх уу. Нэлээн ярилцаад сая бас Сангийн сайд хариулсан. Өнөөдрийн тодорхой гаалийн байгууллага маань боомтуудын асуудал эхэлж байна. Гаалийн байгууллагын хүрээнд боомтуудын маш томоохон.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Булгантуяа сайд тодруулах юм уу. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулбал хамаарахгүй гэхэж байгаа шүү дээ. Тэгэхээр тэгэхгүйгээр өөрийн чинь хэлж байгаа шиг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тэд дүгээр заалт хангасан нөхцөл бүрдвэл гээд ингээд явчхаж бас болох л юм. Булгантуяа гишүүний микрофоныг өгье.

Х.Булгантуяа: Харин тийм ээ. Энэ яг тэгж харагдаад байна лээ. Хэрвээ тодотгол хийнэ л гэх л юм бол орлого тасарлаа. Тодотгол хийнэ гэх юм бол эхлээд төсвийн хүрээгээ өөрчлөөд, 3 сар хүлээгээд, дараа нь тодотголоо өргөн барина гэхээр тэр хооронд төсөв хүндрэхээр нөхцөл байдал үүсчихсэн байгаад байгаа юм. Тэгээд Жавхаа сайд, манай ажлын хэсэг бараг маргааш нөгөөдрөөс бид нар хуулиа өргөн барихаар ажиллаж байна. Тэр дээр бас үүнийг хөндөж болохгүй бол оруулж ирье. Тэгэхгүй бол одоо энийг хөндөөд ороод ирвэл аягүй бол энэ дээрээ фокусалж, маргаан үүсэж байгаад харин тийм суурь хууль хөндлөө гэж маргаан үүсэж байгаад энэ бүтцийнх нь хууль нь батлагдахгүй, тодотгол нь цагтаа орж ирж чадахаа байчхаж бас магадгүй гэж байгаа юм. Гэтэл нэг ийм юм бас харагдаад байгаа Жавхаа сайд аа. Хэрвээ зөвхөн бүтэцтэй холбоотойгоор төсвийн тодотгол хийх гэж байгаа бол зүгээр 1 төсвийн ерөнхийлөн захирагчаас нөгөө ерөнхийлөн захирагч руу л шилжүүлнэ гэсэн үг. Орлого, зарлагаар оролдохгүй юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Тийм байгаа биз. Бас нөгөө талдаа.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя.

Д.Пүрэвдаваа: Өдрийн мэнд хүргэе. Түрүүний Даваасүрэн даргын асуулт дээр тодруулж асуумаар байгаа юм. Одоо бол 3 сайдыг хасчхаж байгаа юм. Хасахаасаа өмнө Засгийн газрынхаа бүтцийг хуучин бүтцээр сайдаа томилчхож байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь эргүүлээд дараа дараа дэд сайдууд ч гэдэг юм уу бусад энэ Засгийн газрын бүтэцтэй холбоотой асуудлуудыг шийдвэрээ гаргачхаад, хуваарилчхаад, тэгээд орж ирэх гээд байгаа байхгүй юу. Засгийн газрын яаралтай горимоор гэдгээр. Тэгээд бодвол шалтгаанаа бол төсвийн тодотгол эд нар гээд явах байх л даа. Тэгэхээр энэ чинь өөрөө ингээд ийм зөрчил болчхоод байгаа байхгүй юу. Энгийнээр бодох юм бол дараа нь дэд сайд хэдэн агентлагтай, ямар бүтэц, бүрэлдэхүүнтэй ажиллах юм бэ гэдэг нь уг нь бол Үндсэн хууль дээрээ Улсын Их Хурал тогтооно, батална гээд заачихсан байгаа юм. Тэгээд Улсын Их Хурал ямар ч мэдээлэлгүй байж байгаад сая бол нөгөө хэлэлцэх үү, үгүй юу гэдэг санал хураахад гишүүдэд мэдээлэл нь ирээгүй шүү дээ. Би бүр Хурлын ажлын албанаас орж ирж байгаа хуулийн төсөлтэй танилцъя гэхэд чинь танилцуулахгүй байсаар байгаад санал хураагаад явчхаж байгаа юм. Тэгээд энэ юу харагдаж байна вэ гэхээр ерөөсөө намын улс төржсөн шийдвэр түрүүлж яваад байна. Аль нэгэн газар шийдвэр түрүүлж гарчхаад байна гэдгийг л илэрхийлж байгаа шүү дээ. Улсын Их Хурлын 1 ч гишүүн яг яаралтай горимоор Улсын Их Хурал дээр хэлэлцэх үү, үгүй юу гэдэг санал асуулга явахад 1 ч хүн материал аваагүй байсан шүү дээ. Энэ бодит жишээ шүү дээ. Энийг баримтаар тайлбарлаадах. Яагаад санал хураалт явахад энэ бүтцийн төсөл бид нарын гарт ирээгүй байсан юм.

Дараагийнх нь хэдхэн жилийн өмнө 2012 он гэхэд миний санаж байхад 20 гаруй л агентлагтай байсан. Одоо 60-аад агентлагтай байна. Төрийн албан хаагчдын тоо бүр улам нэмэгдсэн. Дээрээс нь нэмэгдээд хэлэхэд орон нутгийн үйлдвэрийн газрууд, эдгээрийнхээ яг нэгэнтээ орж ирж байгаа бол хэчнээн хэмжээний бүтэц, бүрэлдэхүүн яг яаж явах юм бэ гэдгээ тодорхой хамт оруулж ирмээр байх юм. Мэдээллээ. Тэгэхгүй болохоор энэ Төрийн албаны хууль дээр болохоор зэрэг халаа сэлгээ хийхдээ төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаална. Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг хамгаална гээд баахан зүйл байгаа. Энэ бүтэц бүрэлдэхүүнээс болоод чөлөөлөгдсөн хүмүүс 3 сарын тэтгэмж авах ёстой хуулиараа. Миний санаж байгаагаар. Дээрээс нь эдгээр хүмүүсээ хэрвээ таны илэрхийлснээр миний сүүлд санаж байгаа нь 14 мянга гаруй албан хаагчдыг чөлөөлнө гэж байгаа юм. Тэгэхээр энэ 3 яамнаас 14 мянга юм уу. Эдийн засгийн хувьд тооцоо нь яаж гарсан юм. Тэгээд .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Энд хариулъя. Ер нь Үндсэн хууль дээр юу гэж байна гэхээр байна шүү дээ. Олонхын яасан юм Ерөнхий сайдыг томилно гэж байгаа юм. Тэрний дараа нь Ерөнхий сайд, Ерөнхийлөгч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөө Ерөнхийлөгчтэй зөвшилцөөд, Их Хуралд танилцуулна гэж байгаа юм.

4-д нь Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч танилцуулаад Ерөнхий сайд томилно. Ийм дараалалтай байгаа байхгүй юу. Гэтэл Үндсэн хуулийн энэ дарааллыг алдагдуулчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр наадах чинь үндсэн хуулийн зөрчил үүсээд байна шүү гээд байгааг та нар бас анхаарах хэрэгтэй байхгүй юу. Зүгээр урдаас маргаад суугаад байх биш. Яагаад гэвэл Үндсэн хууль дээр тэгээд биччихсэн байгаа байхгүй юу. Ерөнхий сайдыг тийм намаас томилно. Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулна. Тэрний дараа сайдаа өөрөө томилно гээд и байж байгаа байхгүй юу.

Тийм учраас энийг урд, хойно нь оруулж байгаа чинь өөрөө Үндсэн хуулийн зөрчил шүү л гэж би хэлээд байгаа байхгүй юу. Тэгээд Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя.

С.Бямбацогт: Түрүүн ярьсан. Монгол Улсын Ерөнхий сайдын онцгой бүрэн эрх болон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг Их Хурлаар батлуулах. Засгийн газрын гишүүнийг томилох. Энэ хүрээндээ энэ бүтэц бүрэлдэхүүнийг сайд нар маань хүлээн зөвшөөрөөд, энэ хүрээнд ажиллана гээд Ерөнхий сайд эхлээд сайд нараа томилсон. Дараа нь бас нөгөө төрийн байгууллагыг цомхон, Засгийн газрыг бас илүү цомхон ажиллах шаардлагын хүрээнд үндэсний хороодыг татан буулгах, зөвхөн энэ 3 Үндэсний хороо биш. Нийтдээ нийт 60 орчим Үндэсний хороо байгаа. Түүнээс 50 хувийг нь татан буулгахаар болж байгаа. Эхний ээлжид яамтай сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллаж байсан 3 Үндэсний хороог татан буулгахаар болж байгаа.

Энэ Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйл дээр Ерөнхий сайдын бас өөрийнх нь бүрэн эрх байгаа. Тэнд юу гэдэг юм Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөх, Засгийн газрын гишүүдэд тодорхой чиг үүрэг хуваарилах, нэгнээс нөгөөд шилжүүлэх энэ бүх асуудлыг бол өөрөө саналаа гаргаад оруулж ирнэ. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын гишүүний чиг үүрэг, яамдын чиг үүрэг өөрчлөхтэй холбоотойгоор сайд нарыг хөндөхгүй байгаад оруулаад явж байсан тийм жишиг байдаг. Тэр эрх нь ч гэсэн хуулиар өөрт нь олгогдсон байгаа. Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн хэдийн хэд билээ байз. 1.6 дахь заалт. Энэ заалтын дагуу л оруулж ирж байгаа юм. Өмнө нь бас Алтанхуяг Ерөнхий сайд байхдаа ч гэсэн бас Алтанхуяг Ерөнхий сайд сайд нарыг хэсэгчилж оруулж ирж байсан. Ийм жишиг байж байгаа. 15 сайдаа эхэлж томилчхоод, дараа нь тодорхой сайд нар сүүлд нь оруулж ирж байсан.

Мөн түрүүн хэлсэн Эдийн засаг, хөгжлийн сайдад Шадар сайд болгоод тодорхой чиг үүрэг нэмж байсан ийм бас урд талын жишгүүд байгаа. Энэ жишгүүд маань яаж байна гэхээр Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1.6-д заасны дагуу л явж байгаа юм. Энийг та бүхэндээ бас хэлье.

Ц.Даваасүрэн: Бямбацогт сайд аа, тэгээд Үндсэн хууль дээр тодорхой заачихсан байгаа байхгүй юу. Засгийн газар, сайд гишүүдээс бүрдэнэ. 39 дүгээр зүйлийн 1.

2.Олонхын суудал авсан намаас Ерөнхий сайдыг нэр дэвшүүлж, томилно.

3.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах бол энэ чинь 3-ыг яагаад өөрчлөлт оруулж байна шүү дээ. Энэ өөрчлөлт оруулснаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж байгаа байхгүй юу. Ингээд Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй 7 хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ. Бүтэц бүрэлдэхүүнээ өөрийнхөө кабинетыг. Энийгээ бүрдүүлсний дараа

4.Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч танилцуулаад, Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Энэ нөгөө бид нарын оруулсан Ерөнхий сайдын давуу эрх.

Тэгэхээр ямар ч өөрчлөлтөө Ерөнхийлөгчтэй зөвшилцөж оруулж ирсэн байх ёстой юм. Энэ чинь байхгүй байна гээд би хэлээд байна шүү дээ. Ямар ч тохиолдолд. Хэлж байна шүү дээ. Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах бол Ерөнхийлөгчтэй зөвшилцөж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй 7 хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ. Энэ дотор Ерөнхийлөгчтэй зөвшилцсөн юм алга л байна шүү дээ. Байхгүй. Байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр байна шүү дээ дараалалтай байгаа байхгүй юу. Энэ чинь Үндсэн хуулиар олгосон дараалал байгаа байхгүй юу. Бямбацогт.

С.Бямбацогт: Үндсэн хуульд таны хэлдэг дараалал байгаа. Тэгээд одоо байгаа бүтэц, бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд хүлээн зөвшөөрөөд, энэ бүтэц, бүрэлдэхүүнээр ажиллая гээд түүний дараагийн процесс руу Засгийн газрын гишүүнийг томилохыг Ерөнхийлөгчтэй зөвшилцөөд, Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд танилцуулаад ингээд Ерөнхий сайд захирамж гаргаад, Засгийн газрын гишүүдээ томилсон. Үүний дараа түрүүн хэллээ шүү дээ. Төрийн албыг бас цомхон чадварлаг болгоё. Бас өөрчлөлтийг өөрсдөөсөө эхэлье гээд яамдын бүтэц, бүрэлдэхүүн рүү үндэсний хороод байх шаардлагагүй юм байна гэж үзээд өнөөдөр үүнтэй холбоотойгоор бүрэлдэхүүний асуудлыг оруулж ирж байгаа. Бүтцийн асуудал биш. Бүрэлдэхүүний. Ингээд бүрэлдэхүүнийхээ асуудлын хуулийг өөрчлөхдөө зайлшгүй Төсвийн хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тодорхой өөрчлөлт оруулж байж Засгийн газар үйл ажиллагаагаа жигдрүүлж, төрийн ажлыг тасралтгүй хурдан шуурхай явуулах бололцоо боломж нь бүрдэх юм байна гэж үүнийг дагуулж Төсвийн болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж ирж байгаа юм. Тийм болохоор таны хэлээд байгаа тэр Үндсэн хуульд заасан бүтэц, бүрэлдэхүүний хуульд өөрчлөлт оруулахгүй. Үүгээрээ ажиллаж болно гээд сайд нараа томилчихсон. Дараагийнхаа процессоор орчихсон. Үүний дараа бүрэлдэхүүнээ томилоод, бүрэлдэхүүнийхээ хуульд өөрчлөлт оруулах асуудлыг оруулж ирж байгаа юм. Үүнийг бас Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцчихсэн.

Ц.Даваасүрэн: Пүрэвдаваа гишүүн тодруулъя. Тэгэхдээ та нар анхаараарай. Одоо засах нэг боломж байгаа юм. Одоо хэрвээ засъя гэвэл та нар яг энэ өөрчлөлт орж байгаа сайд нараа буцаагаад оруулаад, буцаад танилцуулаад, буцаагаад томилчих юм бол ямар ч асуудалгүй болно. Тэгэхгүй явах юм бол Үндсэн хуулийн зөрчил үүсчихсэн байгаа шүү. Пүрэвдаваа гишүүн

Д.Пүрэвдаваа: Бямбацогт сайд аа, ердөөсөө баримтаар нотлогдохгүй байна шүү дээ. Юу вэ гэхээр Улсын Их Хурлын гишүүдэд яг тэр яаралтай горимоор Засгийн газраас орж ирээд бүтцийн асуудал энэ хуульд өөрчлөлт оруулахаар материал тараагдаагүй. Ерөнхийлөгчтэй зөвшилцсөн материал хэзээ хэнд тараагдчихав. Байхгүй шүү дээ. Та нар үндсэндээ бол хууль зөрчсөн нь баримтаар нь тогтоогдчихсон байгаа шүү дээ. Тэгээд энийгээ хүлээн зөвшөөрөөд, залруулаад яв л даа. Тэгэхгүй дахиад л бид нарын эрх нь байгаа. Энэ чинь Улсын Их Хуралд байгаа шүү дээ. Батлах эрх нь.

Ц.Даваасүрэн: Учрал сайд. Бүтэц, бүрэлдэхүүн чинь хоёулаа байгаа юм шүү. 39.3 дээр бүтэц, бүрэлдэхүүн хоёулаа өөрчлөлт орвол Ерөнхийлөгчтэй зөвшилцөж байж гэдэг чинь Ерөнхийлөгчтэй албан ёсны бичиг явна гэсэн үг. Тэгээд Ерөнхийлөгч хариу өгсөн байх ёстой. Энэ чинь зөвшилцөнө гэдэг чинь тэр шүү дээ. Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Энэ ээлжит сонгуулийн дараа 7 дугаар сарын 9-нд байна уу. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуулийг Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд зөвшилцөөд батлуулсан. Тэгэхээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухайн үед батлагдаж байсан хууль өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Нэг ёсондоо Үндсэн хуульд бол Ерөнхий сайд, Ерөнхийлөгчтэй Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг зөвшилцөөд гэдэг үг байгаа болохоос биш шинээр заавал Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуулийг боловсруулж оруулж ир гэсэн агуулга байхгүй. Тэгэхээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд сайд нараа томилсон гэсэн үг. Тэгэхээр яг энэ жишгийн дагуу бол тэр Батболд Ерөнхий сайд яг хуучин бүтэц, бүрэлдэхүүний хууль дээрээ сайд нараа томилж байсан. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд бас 2021 оны 1 дүгээр сарын 29-нд бас яг хуучин хууль дээр нь томилж байсан. Бид сая бол томилсныхоо дараа Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуулиа сая дахиж өргөн мэдүүлэхдээ хооронд нь чиг үүрэг өөрчлөгдсөн учраас .../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Учрал сайд 1 минут.

Н.Учрал: Тэгэхээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд сайд нараа томилоод, 3 үндэсний хороотой сайдаа буулгая гэхээр төсвийн асуудал хөндөгдсөн. Төсвийн тогтвортой байдлын хуулийн 3 сар гэдэг заалт байсан. Ингээд Засгийн газрын хуулийн 23.1.6 дахь заалтын дагуу эрхлэх ажлын хүрээнд хооронд нь шилжүүлэх шаардлагатай, нэмэлт ажил үүрэг хариуцуулах шаардлагатай бол эрхлэх асуудлыг нөгөөд нэгээс шилжүүлэхдээ Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэсэн Засгийн газрын хуулиа бариад, Ерөнхийлөгчид Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуулиа зөвшилцөөд, тэр зөвшилцсөн бичгээ Бямбацогт сайд хавсаргаад, ингээд энэ удаа орж ирж байгаа гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр Засгийн газрын хуулиа барьж байгаа.

Ц.Даваасүрэн: Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгчтэй 6 сарын 20-нд зөвшилцсөн бичиг ирүүлсэн байгаа. Тэгэхээр сайд нар чинь хэзээ томилогдлоо гэдгийг яриад байна шүү дээ. Дараалал чинь алдагдсан байна.

Н.Учрал: Тэр бол өмнөх хуулиараа угаасаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хуулиараа л томилогдсон байна. Дахиад зөвшилцсөн. 2 удаа зөвшилцсөн байхгүй юу.

Ц.Даваасүрэн: Тэрийгээ анхаараарай та нар. Яагаад гэвэл Үндсэн хууль дээр чинь эхэлж зөвшилцөнө, дараа нь сайд нараа томилно гэж байж байгаа байхгүй юу. Зүгээр тэрийгээ анхаар гээд гишүүд хэлээд байхад та нар тэгээд урдаас яагаад байх юм. Алдаатай байвал энийгээ засаад л яв л даа гээд байна шүү дээ. Яагаад гэвэл Үндсэн хууль дээр дарааллын заагаад өгчихсөн байгаа байхгүй юу. Тэрийг яриад байгаа юм. Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Би асуулт асуухгүй зүгээр үг хэлэх гэсэн юм. Уг нь Занданшатар Ерөнхий сайд өөрөө ороод ирсэн бол би Засгийн газар шинээр байгуулагдаад, бүтэц, бүрэлдэхүүнийхээ тухай хуулийг болон дагалдуулах хуулиудаа өөрчилж байгаа дээр нь яг зөвлөмж байдлаар гэх юм уу, хэдэн үг хэлэх гээд. Өчигдөр Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар төсвийн 2024 оны Засгийн газрын санхүүгийн тайлангийн талаар хэлэлцсэн. Тэгээд энэ хэлэлцсэн асуудал дээр маш хариуцлагагүй тоонууд нэлээн их яригдсан. Хэрэг эрхлэхийн дарга байна. Тэргүүн Шадар сайд байна. Сангийн сайд

байна. 15 их наяд 719 тэрбум 900 сая төгрөгийн асуудал, зөрчил дутагдал алдаатайгаар аудитын тайлангаар илэрч гарч ирсэн. Тэгэхээр энэ Төсвийн тухай хууль дээр бас байна зарчим. Энэ 5 дугаар зүйл дээр зарчим байна. Хариуцлагатай байх ёстой. 6 дугаар зүйл дээр төсвийн зарчмыг хэрэгжүүлэх ёстой. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байлгах ёстой. Төсвийн ерөнхийлөн захирагч нь томилсон байгууллагынхаа өмнө хариуцлага хүлээнэ.

Тэгээд 6.6.3 эрх үүргээ доош нь шилжүүлэх боломжтой ч гэсэн дээд шатныхаа өмнө хариуцлагаа хүлээнэ.

14.4 дээр энэ хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Тэгээд 40.4.2 дээр урамшуулал өгч болно. Хариуцлагыг нь бас тооцох ёстой гээд. Тэгээд 70 дээр энэ хариуцлага хүлээх ёстой. Энэ нь ингээд гэмт хэргийн шинжгүй бол төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ гээд. Жишээлэхэд Хэрэг эрхлэхийн дарга бол өчигдөр бас тэр хэлэлцүүлгийн үеэр өөрөө хэлсэн. Яг ингээд 30 жил яваад ирчихсэн юм байна лээ гээд. Тэгэхээр одоо энэ Занданшатарын гэдэг тодотголтой энэ Ерөнхий сайдын үед хийгдэж байгаа Засгийн газар, та хэд хариуцлага гэдэг юмыг нэг тооцдог болоод өгвөл та хэд бол яах вэ, сайд нар ч бай, дарга нар ч бай хэн нэгэн томилогдоод, үеэ өнгөрөөгөөд явчихдаг. Асуудал нь авлигатайгаа цуг Монголд гай болж үлдээд байна гэдгийгээ бас та хэд яг засаг бүрэлдэж байгаа энэ үе дээрээ анхаараад, хариуцлагатай ажиллаад өгөөрэй гэж та бүхнээс хүсэх гэсэн юм.

Ц.Даваасүрэн: Санал юм байна. Ингээд энэ 3 яамыг Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнээс хасаж байгаатай холбогдолтой төсвийн өөрчлөлтийн 2 дугаар зүйлийг хэлсэн. Энэ дээр ер нь анхаараарай. Тэр Хүрэлбаатарыг томилоход бол эхлээд Засгийн газрынхаа бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулчихаад, дараа нь Хүрэлбаатар томилогдсон байхгүй юу. Хүрэлбаатарыг томилчихоод өөрчлөлт оруулаагүй. 2 дугаар зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан 3 байсан юм уу. Уучлаарай 3 дугаар зүйл шүү. 3 дугаар зүйл дээр зарчмын зөрүүтэй санал алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу. Нэрээ өгөөрэй. Алтанхуяг гишүүн асуултаа асууя. Алтанхуяг гишүүний микрофон өгье.

Н.Алтанхуяг: Та нарт дахиад нэг юм хэлье. Би бол та нарыг хурдан ажлаа эхлээсэй гээд байгаа юм. Тэгэхдээ 1 ийм хуулийн зөрчилд ороод юм чинь бантан болох вий. Бямбацогт сайд энэ бүтэц, бүрэлдэхүүн гэдэг бол их ноцтой юм байхгүй юу. Би бол Даваасүрэн даргатай санал 1 байгаа. Кабинетаа байгуулахын тулд ямар сайдын эрхлэх асуудлын хүрээнд юуг хариуцуулах гэдэг бол галзуу том бодлого. Жишээ нь манай яам гарахад бид нар Хөдөлмөрийн яам гэж тусдаа байгуулъя. ЖДҮ-г хаана өгөх вэ гэхээр хөдөлмөр эрхэлдэг хүмүүсээ дэмжих учраас тийшээ өгнө. Олон жил миний өмнөх Засгийн газрууд дээр гардаг байсан маргаан бол МСҮТ нь боловсролдоо байх уу, энэ хөдөлмөр тал руугаа байх уу. Энийг хөдөлмөр тал руугаа өгье. Тэгвэл нөгөө танхимын цаг нь багасна гээд бүгд бодлого байхгүй юу. Ингэж ингэж яагаад зурдаг байхгүй юу. Тэгээд хүн байхгүй байхад буюу шинэ сайд томилогдоогүй байхад энэ бодлогын бүтэц бол Улсын Их

Хурлаар орж батлагддаг. Би бол Пүрэвдаваа гишүүнтэй санал нэг байгаа юм. Та нар маань энэ дээрээ алдчихсан юм биш үү. Тэгээд одоо зүтгүүлээд баталсан болоод гаргаад бантан болов л гэж би санаа зовоод байна. Би та нарыг ажлаа хурдан эхлээд өгөөч ээ л гэж хүсээд байна шүү дээ. Тэр Хүрэлбаатар сайдынх чинь бол хулгай байсан байхгүй юу. Засгийн газрын бүтцэд тэр Шадар сайд билүү тийм юм бий болгоно гэж оруулж ирж батлуулах ёстой байхад төсвийн тодотгол дээр тэр дагалдаж явсан юм. Та бол андуураад байх шиг байх юм. Бямбацогт сайд. Би бол тэр дээр чинь бүр гардсан. Бүр тэр ТӨХ ямар сайдын мэдэлд очвол зөв байх вэ гэж. Саяын боомт чинь бол Жавхлан Сангийн сайдын мэдэлд биш ээ. Энэ бол салбар дунд болчхоод байдаг байхгүй юу. Яг сая Булгантуяа гишүүний хэлээд байгаа Гаалийнхаа атамандана, Хилийн цэрэг атамандана, Мэргэжлийн хяналт атамандана гээд сүүлдээ бид нар яам хүртэл байгуулаад, янз бүрийн сайд тавиад энэ чинь бол Шадар сайд дээр очих ёстой юм. Ямар Шадар сайдыг би мэдэхгүй байна. Ингэж эхлээд энэ бүтэц бүрэлдэхүүн гээд байгаагийн цаана асар том бодлого зангидагдаад, тэгээд дараа нь хүнээ ярьдаг байхгүй юу. Бүр дээр үед ямар юм болж байсан юм гэхээр Сангийн сайд, Үйлдвэр худалдааны сайд 2-ын хооронд гадаадын зээл тусламжийн асуудал гэдэг юмны маргаан үүсэж байсан. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн батлагдсаны дараа маргаан үүсээд, тийшээ байна ийшээ байна гээд арга байхгүй Сангийн сайд дээр үлдэж байсан юм. Тэгэхээр ийм бодлогын юм байхгүй юу. Та нар яагаад ингээд байгаад байгаа юм.

Эсвэл Булгантуяагийн хэлж байгаа шиг зөвхөн төсөв шилжүүлэх гээд байгаа юм уу. Тэгэхдээ бодлого гарч байж, батлагдаж байж дараа нь сайдын тухай ярьдаг л даа. Ингээд та нар бодоорой. Би бол та нарыг зөв болгоод явбал хэрэгтэй юм уу гэж бодсон. Үүгээрээ зүтгүүлье гэвэл хамаагүй зүтгүүлээд л яв.

Ц.Даваасүрэн: Ер нь Ерөнхий сайд бол кабинетынхаа бүтэц, бүрэлдэхүүнийг батлуулж байж явах ёстой л доо. 4 дэх асуудал дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу. Алга байна.

Ингээд Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй. Зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу. Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулж байгаа нэмэлт шигтгээнүүд бол яг зөв юм байна лээ. Нийтлэг ойлгогдох гээд байгаа зүйлүүдийг тодорхой болгож өгч байгаа юм. 2025 оны 6 сарын 1-ний дотор бид 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсөөлөл баталсан байхгүй юу. Одоо яриад байгаа төсвийн тодотголын асуудал чинь бол 2024 оны 12 сард ярьсан төсвийн хүрээ байхгүй юу. Тэгээд үүнийгээ ялгаж өгч байгаа явдал нь зөв. Цаашид практик талаасаа зөв гэж. Сая манай гишүүд олон талаас нь яриад байна. Би бол энд хуулийн гажаа гарчихсан гэж ерөөсөө ойлгохгүй байгаа.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулиа бариад, Засгийн газрын үйл ажиллагааныхаа хөтөлбөр, бодлогыг үргэлжлүүлье. Үүнийгээ тогтвортой

байлгая гээд тэр дээрээ сайд нараа томилчихсон. Одоо эргээд 3 Үндэсний хороог нь татан буулгаад, холбогдох салбарууд дээр нь чиг үүргийг нь өгчихье гэж. Энэ Засгийн газрын тухай хуулиараа Ерөнхий сайдад байж байгаа бүрэн эрх нь. Энийгээ харин Их Хурал руу оруулж ирүүлээд батлуулчих ёстой. Энэ процесс нь болж байгаа юм байна гэж хараад байгаа юм.

Харин тэр Төсвийн тухай хуулийн 28.6 шиг санаад байна. Саяын бидний тойрч ярьсан асуудал бол. Энэ дээр харин 1 үг илүүдчихээд байгаа юм гэж ойлгоод байгаа юм. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт ороход төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт орох тухай асуудал байхгүй байхгүй юу. Харин төсөвт бол тодотгол орж болно. Яагаад вэ гэхээр нэгээс нөгөөд зардал юмнууд гүйж байгаа учраас энэ нь бол хүлээн зөвшөөрөгдөх ёстой. Төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол бид үндсэндээ нэг бол доод босго, нэг бол дээд хязгаар л баталж байгаа улс шүү дээ. Тэр дотроо хэрхэн зохицуулах вэ гэдэг асуудал нь бол үндсэндээ Засгийн газрын өөрийнх нь эрх, үүрэг. Түүнийгээ Их Хуралдаа орж ирж баталгаажуулах тухай л ойлголт. Тийм учраас би энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлийг бүрэн дэмжиж байгаа юм гэдгээ хэлье.

Бас гишүүддээ ерөнхий ойлголт өгөх талаас нь хэлэлцээд өнгөрчихсөн хуулийн юун дээр нь тодорхой ийм санал бодол илэрхийлж байна.

Ц.Даваасүрэн: Санал юм байна шүү дээ. Ер нь та тэр Үндсэн хуулийн 39.1-4-ийг хараарай. Хэрвээ Засгийн газрын бүтцэд өнөөдрийнх шиг бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж байгаа бол заавал томилохоосоо өмнө оруулах ёстой юм байна лээ. Ерөнхийлөгчтэй зөвшилцөөд. Энэ дараалал нь байгаа байхгүй юу. Тэгээд хэрвээ оруулж ирэхгүй байгаа бол үгүй ээ, өмнөхөө хүлээн зөвшөөрч байгаа бол тэрийгээ оруулах ёстой байсан байхгүй юу. Оруулаад Ерөнхийлөгчтэй зөвшилцөөд. Хэрвээ тэрийг нь жишээлбэл Ерөнхийлөгч зөвшилцөхгүй бол өөрөө 5 хоногийн дотроо шууд Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж байгаа байхгүй юу. Хуучин бүрэлдэхүүнээр ч бай. Яагаад гэвэл тэр хүн чинь кабинетаа бүрдүүлж байгаа хүн байгаа байхгүй юу. Тэрийг тэгээд Цэц шийдэг. Тэр Цэц нь шийднэ биз. Бид нар ямар тэр хууль дээр тайлбар өгөх биш. Зүгээр л хуулийн асуудал, зөрчлийн тухай л ярьж байна шүү дээ.

1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт дууслаа. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хороонд Батжаргал гишүүн байгаа юу. Байхгүй ээ. Хэн байгаа юм. Төрийн байгуулалтад манайхаас хүн байдаггүй юм уу. Манай байнгын хорооных биш болохоор болохгүй л дээ. Соёлмаа гишүүн. Уучлаарай. Мөнхсоёл гишүүн. Хагас дуудчихлаа Мөнхсоёл оо.

11.19 цаг.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар оролцож байгаа юм байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 2 зүйлтэй. Тэгээд тус бүрээр хэлэлцэж эхэлье.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна. 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Батжаргал гишүүн. Кнопоо даръя. Нэрээ өгье. Батжаргал гишүүний микрофоныг нээе. Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр хэрэгжих хугацааг 7 сарын 1-ээс гээд орчхоод байгаа юм. Тэгэхээр зэрэг тэр дээр харин хууль эцэслэн батлагдаад, тэгээд тодорхой институц хуульд хяналт тавиад, тэгээд хэрэгжих юутайгаа нийцэж байгаа болов уу гэдэг л асуудал байна. Тодруулах зүйл. ш

Ц.Даваасүрэн: Энхбаяр сайд аа, 7 сарын 1 гэдэг чинь нөгөө Ерөнхийлөгчийн хориг 5 хоногтойгоо нийцэж байна уу гэж байна. Хариулъя. 4 номерын микрофон өгье.

Ж.Энхбаяр: Энэ Ерөнхийлөгчийн Тамгын газартай зөвшилцсөн хэрвээ Улсын Их Хурал асуудлаа цаг хугацаандаа баривал Ерөнхийлөгчийн Тамгын газраас ямар нэгэн хориг тавих зүйл байхгүй. Хуулийг батлахад дэмжсэн бичиг өгнө гэдгээ илэрхийлсэн. Тэгэхээрээ 1 зүйл байгаа юм. Байнгын хорооны даргаас хүсэхэд 4 дэхийн хэлэлцүүлгийн дараа та эцсийн хэлэлцүүлгийг эцсийн найруулга сонссоноор тооцлоо гээд шууд шийдчихвэл хуулийн хугацаандаа бүрэн багтана л гэсэн үг.

Ц.Даваасүрэн: Яах вэ ер нь Тамгын газартаа бас сайн ярья. Нөгөө ёсчлох асуудал нь бас 1, 2 өдөр болчих гээд байдаг юм шүү дээ гарын үсэг. Одоогийн энэ нөгөө түрүүний хэлэлцсэн 2 хурал дээр ч гэсэн Жавхлан сайд нөгөө 5 хоногийн хугацааг бас анхаараад, саяынх шигээ ингээд түргэвчилчих юм бол амжина. Түргэвчлэхгүй зүгээр өмнөхөөрөө ингээд явна гэх юм бол наадах чинь ёсчлох гэж 2 өдөр болно шүү. Ойлгомжтой. 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж дууслаа.

2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.24-д заасны дагуу хуулийн төслийг анхны хэлэлцүүлэг нь эцэслэн батлах үе шат руу шилжүүлбэ гэсэн горимын санал гаргаж байна. Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдье. Анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Бэлдээрэй. Хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Систем гагцчихсан уу. Хүчингүй болгоё. Дахиад явуулъя. Хүчингүй болгоё. Ахиад бэлдье. Манай техникийнхэн анхаараарай. Энэ чинь ажиллахгүй байна шүү. Дахиад бэлэн байдалд шилжүүлбэ. Санал хураахад бэлэн болгох хэрэгтэй байна. Тэгээд та нар бэлэн болохоор нь надад хэлчих.

Дамдинням гишүүн горимын санал гаргая гэж байна. Дамдинням гишүүний микрофоныг өгье.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь эцэслэн баталъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Бэлдчихсэн байх ёстой байхгүй юу. Ахиад ажиллахгүй байна шүү дээ. Ахиад ажиллахгүй байна.

Техникийн шалтгааны улмаас санал хураалт болох боломжгүй байгаа учраас горимын санал гаргаад гараар санал хураалт явуулъя гэдэг горимын санал гаргаж байна. Горимын саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. Тоолоорой. 19-12 дэмжигдсэн байна. Тийм учраас гар өргөж горимын саналыг хураа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нь эцэслэн баталъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. 19-12. 63,2 хувь. Горимын санал дэмжигдлээ.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооноос гарах санал дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд Болормаа гишүүн танилцуулчих уу. Болормаа гишүүн нэгдсэн хуралдаан танилцуулъя.

Төсвийн байнгын хорооны хуралдаанд горимын саналаар ажлын хэсэг байгуулах саналыг Батжаргал гишүүн гаргасан. Гишүүд ээ, байж байгаарай 1 санал хураалт явна. Чойжилсүрэн гишүүн байж байгаарай.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоол гаргая гэж Батжаргал гишүүний горимын санал дэмжигдсэн учраас ажлын хэсэг байгуулах шаардлагатай. Яагаад гэвэл Байнгын хорооны ч бай хуулийн төслийг заавал гишүүд боловсруулах учраас Батжаргал гишүүнээр ахалсан ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлаар “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ж.Батжаргал, ажлын хэсгийн гишүүн Р.Батболд, М.Бадамсүрэн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоол байна.

Орох юм уу. Тэгвэл Заяабал гишүүнийг оруулчихъя. Өөр орох гишүүн байна уу. Саналаараа. Заяабал гишүүнийг гишүүд дэмжиж байгаа юм уу. Санал хураачихъя. Тэгвэл Заяабал гишүүнийг бүгд дэмжиж байгаа учраас Заяабал гишүүн орууллаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна. Тэгвэл “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 19 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 63.2 хувиар дэмжигдсэн байна.

Ажлын хэсэг байгуулах тогтоолын төсөл батлагдлаа.

Төсвийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүд.

11.28 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ